



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 5/10

Буянт

Л.Бүрнээбаатарт мөнгөн урамшуулал
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө, орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа олгох зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг Тамгын газрын даргаар ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан Лхамсүрэнгийн Бүрнээбаатарт нөхөж олгосугай.

2. Холбогдох хууль, тогтоомжийн дагуу мөнгөн урамшууллалыг бодож олгохыг Нягтлан бодогч (А.Отгонцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Б.Золзаяа)-д даалгасугай.

ДАРГА

Д.ЛХАГВАДОРЖ



642301553



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 6/09

Буянт

М.Саранчимэгийг цалинг шинэчлэн
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.22, Төрийн албаны тухай хуулийн 43 дүгээр зүйлийн 43.3.2, Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.4 дэх зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Мандахын Саранчимэгийг 2024 оны 06 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн түр томилсугай.

2. Байгууллагын үйл ажиллагааг шинэ шатанд гаргаж, албан хаагчдыг хариуцлагжуулж Тамгын газрын даргын ажил үүргийг бүрэн хариуцаж, үр бүтээлтэй ажиллахыг (М.Саранчимэг)-д даалгасугай.

3. М.Саранчимэгийн үндсэн цалинг ТЗ-5 зэрэглэлээр тогтоож, зэрэг дэвийн нэмэгдэл-18%, ажилласан жилийн нэмэгдэл-6%, ЭБАТ-ын нэмэгдэл-10%, Орон нутгийн нэмэгдэл-45%-иар олгохыг Нягтлан бодогч (А.Отгонцэцэг)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Б.Золзаяа)-д даалгасугай.

ДАРГА

Д.ЛХАГВАДОРЖ



642301543